

# “ХААН СОЁМБО АУДИТ- ХХК



## САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

### Аудитын код: ХӨА-2025/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
www.audit.mn  
Хөвсгөл аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn  
Аудитор: Л.Мөнх-Оргил  
Утас: 99039344 Цахим хаяг: munkhorgill@audit.gov.mn  
Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn  
Гүйцэтгэсэн аудитор: Л.Оюунчимэг  
Утас: 99142061 Цахим хаяг: Khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/140  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АРБУЛАГ СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ч.САРАНЦЭЦЭГ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 3,713.9 мянган төгрөгийн бараа материал, 52,058.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн гүйцэтгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 13,911.0 мянган төгрөгийн 6 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн Боловсролын газрын даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 5 хөтөлбөр, 21 арга хэмжээний хүрээнд 76.4 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

670501461

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>255,052,060.31</u></b>	<b><u>278,042,773.73</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	105,152,037.53	136,152,157.30
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	105,152,037.53	136,152,157.30
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	105,152,037.53	136,152,157.30
31211	Төрийн сангийн харилцах	105,152,037.53	136,152,157.30
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	36,281.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	36,281.55
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	149,900,022.78	141,854,334.88
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,112,438.01	4,824,638.01
35110	Тусгай зориулалттай материал	1,781,638.00	1,781,638.00
35130	Эм боох материал	3,330,800.01	3,043,000.01
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	144,787,584.77	137,029,696.87
35410	Бичиг хэргийн материал	576,100.00	411,500.00
35420	Аж ахуйн материал	4,209,721.00	3,992,570.00
35440	Түлш, шатах тослох материал	9,390,005.00	11,916,795.00
35450	Барилгын засварын материал	14,239,200.00	17,172,200.00
35460	Хүнсний материал	21,354,957.00	8,194,280.10
35470	Бусад хангамжийн материал	95,017,601.77	95,342,351.77
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>913,907,765.38</u></b>	<b><u>922,036,048.10</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	913,907,765.38	922,036,048.10
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	893,939,365.38	902,067,648.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,076,066,556.25	1,076,066,556.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-233,651,247.95	-263,346,676.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,247,438.08	93,640,371.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,039,106.42	-42,722,865.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,100,292.62	62,490,406.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,880,950.60	-30,958,527.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,690,475.20	22,950,475.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,802,475.48	-19,260,475.60
39217	Ном	3,208,383.68	3,208,383.68
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>19,968,400.00</u></b>	<b><u>19,968,400.00</u></b>
39301	Програм хангамж	00.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,243,400.00	19,968,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,168,959,825.69</u></b>	<b><u>1,200,078,821.83</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,387,080.00</u></b>	<b><u>857,571.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,387,080.00	857,571.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,387,080.00	857,571.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,024,500.00	857,571.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	362,580.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	362,580.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,166,572,745.69</u></b>	<b><u>1,199,221,250.83</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,166,572,745.69	1,199,221,250.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	165,575,620.45	165,575,620.45
51101	Өмч: - төрийн	165,575,620.45	165,575,620.45
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	943,342,266.43	972,497,017.57
51210	Өмнөх үеийн үр дүн	943,342,266.43	943,342,266.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	32,648,505.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,654,858.81	57,654,858.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,168,959,825.69</u></b>	<b><u>1,200,078,821.83</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>551,839,050.00</b>	<b>731,990,447.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,861,650.00</b>	<b>54,542,447.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,861,650.00	54,542,447.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,861,650.00	54,542,447.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - ҮХ		50,723,547.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – БМ	3,756,650.00	3,713,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>547,977,400.00</b>	<b>677,448,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	521,374,000.00	643,767,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	521,374,000.00	643,767,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	26,603,400.00	33,680,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,603,400.00	33,680,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>491,307,227.67</b>	<b>699,355,695.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>491,307,227.67</b>	<b>699,355,695.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	490,126,847.79	697,926,527.80
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>334,642,291.73</b>	<b>506,256,446.23</b>
210101	Үндсэн цалин	240,556,796.16	345,133,717.83
210102	Нэмэгдэл	72,144,928.87	146,879,748.40
210104	Урамшуулал	21,940,566.70	14,242,980.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>41,629,694.64</b>	<b>57,898,373.79</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,421,284.54	37,926,354.91
210202	Тэтгэмжийн даатгал	3,309,099.60	4,911,007.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,647,320.69	2,583,484.02
210204	Ажилгүйдлийн даатгал	633,485.22	2,441,579.02
210205	Эрүүл мэндийн даатгал	6,618,504.59	10,035,947.94
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,064,958.83</b>	<b>20,587,531.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,369,958.83	6,505,031.94
210302	Түлш, халаалт	8,620,000.00	13,783,000.00
210303	Цэвэр, бохир ус	75,000.00	299,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,447,240.00</b>	<b>7,098,878.66</b>
210401	Бичиг хэрэг	2,745,900.00	2,336,120.00
210402	Тээвэр, шатахуун	2,282,000.00	3,470,671.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800.00	228,836.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,376,540.00	1,063,251.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	41,145,644.20	45,464,682.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	287,800.00
210502	Хоол, хүнс	41,145,644.20	45,176,882.90
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,891,500.00</b>	<b>6,444,200.00</b>
210604	Урсгал засвар	1,891,500.00	6,444,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>731,100.00</b>	<b>675,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	731,100.00	675,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	48,574,418.39	53,501,414.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,961,900.00	8,586,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,612,518.39	44,914,764.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,180,379.88</b>	<b>1,429,168.06</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,180,379.88	1,429,168.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,180,379.88	1,429,168.06
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>60,531,822.33</b>	<b>32,648,505.14</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	275,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	275,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	275,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	275,000.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>60,531,822.33</b>	<b>32,648,505.14</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	145,607,220.45	7,286,909.00	971,428,104.98	1,124,322,234.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	145,607,220.45	7,286,909.00	971,428,104.98	1,124,322,234.43
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-40,743,329.15	-40,743,329.15
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,575,620.45	57,654,858.81	943,342,266.43	1,166,572,745.69
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,575,620.45	57,654,858.81	943,342,266.43	1,166,572,745.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	165,575,620.45	57,654,858.81	943,342,266.43	1,166,572,745.69
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	32,648,505.14	32,648,505.14
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,575,620.45	57,654,858.81	975,990,771.57	1,199,221,250.83

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>548,082,400.00</b>	<b>677,553,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>547,977,400.00</b>	<b>677,448,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	521,374,000.00	643,767,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	521,374,000.00	643,767,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	26,603,400.00	33,680,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,603,400.00	33,680,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>464,079,988.37</b>	<b>646,552,880.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>464,079,988.37</b>	<b>646,552,880.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>462,899,608.49</b>	<b>645,123,712.17</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	333,642,291.73	506,256,446.23
210101	Үндсэн цалин	239,556,796.16	346,709,638.81
210102	Нэмэгдэл	72,144,928.87	146,133,369.63
210104	Урамшуулал	21,940,566.70	13,413,437.79
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>41,629,694.64</b>	<b>57,920,891.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,421,284.54	36,101,374.63
210202	Тэтгэмжийн даатгал	3,309,099.60	5,209,816.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,647,320.69	3,584,976.79
210204	Ажилгүйдлийн даатгал	633,485.22	2,604,934.27
210205	Эрүүл мэндийн даатгал	6,618,504.59	10,419,788.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,319,620.12</b>	<b>22,873,931.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,746,720.12	6,505,031.94
210302	Түлш, халаалт	13,497,900.00	14,996,800.00
210303	Цэвэр, бохир ус	75,000.00	1,372,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>46,541,802.00</b>	<b>31,862,206.00</b>
210502	Хоол, хүнс	46,541,802.00	31,862,206.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,103,400.00</b>	<b>9,377,200.00</b>
210604	Урсгал засвар	6,103,400.00	9,377,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>956,100.00</b>	<b>675,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	956,100.00	675,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,706,700.00</b>	<b>16,158,036.66</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,834,700.00	13,885,396.66

**Хөвсгөл аймгийн Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,872,000.00	2,272,640.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,180,379.88</b>	<b>1,429,168.06</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,180,379.88	1,429,168.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,180,379.88	1,429,168.06
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>84,002,411.63</b>	<b>31,000,119.77</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	84,002,411.63	31,000,119.77
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	21,149,625.90	105,152,037.53
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	105,152,037.53	136,152,157.30

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (улсын төсөв)**

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨ Ө	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	105,152,037.53		
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>748,989,600.00</b>	<b>612,872,580.23</b>	<b>136,117,019.77</b>	<b>81.8</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>748,989,600.00</b>	<b>612,872,580.23</b>	<b>136,117,019.77</b>	<b>81.8</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>748,989,600.00</b>	<b>612,872,580.23</b>	<b>90,895,253.77</b>	<b>84.8</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>597,151,700.00</b>	<b>506,256,446.23</b>	<b>66,300,861.19</b>	<b>83.9</b>
Үндсэн цалин	413,010,500.00	346,709,638.81	24,893,230.37	85.4
Нэмэгдэл	171,026,600.00	146,133,369.63	-298,837.79	102.3
Урамшуулал	13,114,600.00	13,413,437.79	10,339,108.66	84.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>68,260,000.00</b>	<b>57,920,891.34</b>	<b>10,316,825.37</b>	<b>77.8</b>
Тэтгэврийн даатгал	46,418,200.00	36,101,374.63	249,383.21	95.4
Тэтгэмжийн даатгал	5,459,200.00	5,209,816.79	-854,576.79	131.3
ҮОМШӨ ний даатгал	2,730,400.00	3,584,976.79	125,465.73	95.4
Ажилгүйдлийн даатгал	2,730,400.00	2,604,934.27	502,011.14	95.4
Эрүүл мэндийн даатгал	10,921,800.00	10,419,788.86	23,783,294.00	57.3
<b>Нормативт зардал</b>	<b>55,645,500.00</b>	<b>31,862,206.00</b>	<b>23,783,294.00</b>	<b>57.3</b>
Хоол, хүнс	55,645,500.00	31,862,206.00	983,100.00	40.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>1,658,100.00</b>	<b>675,000.00</b>	<b>983,100.00</b>	<b>40.7</b>
Мэдээллийн технологийн зардал	1,658,100.00	675,000.00	10,116,263.34	61.5
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,274,300.00</b>	<b>16,158,036.66</b>	<b>6,974,903.34</b>	<b>66.6</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	20,860,300.00	13,885,396.66	3,141,360.00	42.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,414,000.00	2,272,640.00	105,216,800.00	86.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>748,989,600.00</b>	<b>643,872,700.00</b>		
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>643,767,700.00</b>	<b>643,767,700.00</b>	00.00	<b>100.0</b>
Улсын төсвөөс санхүүжих	643,767,700.00	643,767,700.00	00.00	100.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>				
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	105,000.00	(35,000.00)	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	105,151,900.00			-
	-			-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>105,152,037.53</b>	<b>(105,152,037.53)</b>	
	-			-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>136,152,157.30</b>	<b>(136,152,157.30)</b>	

**Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (орон нутгийн төсөв)**

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>33,680,300.00</b>	<b>32,251,131.94</b>	<b>1,429,168.06</b>	<b>95.76</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>33,680,300.00</b>	<b>32,251,131.94</b>	<b>1,429,168.06</b>	<b>95.76</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>33,680,300.00</b>	<b>32,251,131.94</b>	<b>1,429,168.06</b>	<b>95.76</b>

<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,100,000.00</b>	<b>22,873,931.94</b>	<b>1,226,068.06</b>	<b>94.91</b>
Гэрэл цахилгаан	7,600,000.00	6,505,031.94	1,094,968.06	85.59
Түлш, халаалт	15,000,000.00	14,996,800.00	3,200.00	99.98
Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,372,100.00	127,900.00	91.47
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>9,580,300.00</b>	<b>9,377,200.00</b>	<b>203,100.00</b>	<b>97.88</b>
Урсгал засвар	9,580,300.00	9,377,200.00	203,100.00	97.88
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>33,680,300.00</b>	<b>32,251,131.94</b>	<b>1,429,168.06</b>	<b>100.00</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>33,680,300.00</b>	<b>32,251,131.94</b>	<b>1,429,168.06</b>	<b>100.00</b>
Орон нутгийн төсвөөс	33,680,300.00	32,251,131.94	1,429,168.06	100.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>0.00</b>	<b>(0.00)</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>0.00</b>	<b>(0.00)</b>	<b>-</b>

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 39,210.1 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 2 залруулга хийж, 4 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1 Аудитын залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулга хийгээгүй болно.

### 5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Аудитын явцад албан шаардлага өгөөгүй болно.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой

##### 1.1 Илрүүлэлт

Төсвийн захирагч нь 15 багш ажилтанд нийт 15,442.6 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа нэмэгдэл хөлс тооцож олгох батлагдсан маягтыг хөтлөөгүй байна. Энэ нь Засгийн газрын "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ" заалттай нийцэхгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Илүү цагийг тооцож олгохдоо Засгийн газрын "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгт хөтлөх

##### 2.1 Илрүүлэлт:

Төсөв захирагчийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулаагүй, дүгнэлт гаргаагүй, ур чадварыг хагас жил тутам үнэлээгүй, төсөв захирагчийн 9 удаагийн тушаалаар 28 багш, ажилтны ур чадварын нэмэгдэлд нийт 14,790.3 мянган төгрөгийг олгосон.

## 2.2 Өгсөн зөвлөмж:

Ур чадварын нэмэгдлийг олгохдоо төсөв захирагчийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулан, үнэлэх

## 3.1 Илрүүлэлт:

Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн зардлаас ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 3,283.2 мянган төгрөгийг зарцуулсан.

## 1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчихгүй байх

### 1.1 Илрүүлэлт:

Арбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг нь өөрийн ажил үйлчилгээний онцлогт нийцүүлэн автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоогоогүй, жолоочийн тооцооны хуудсыг хөтлөхдөө спидометрийн заалтыг бичээгүй, багш ажилтнуудад аймаг улсын чанартай тэмцээн уралдаан, сургалт семинарт оролцоход шатахууныг төсвийн захирагчийн албан бичгээр олгож нийт 36 багш, ажилтанд 3,730.2 мянган төгрөгийн шатахууныг тооцоо бодолгүйгээр зарцуулсан байна. Энэ нь *Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаал*-тай нийцээгүй ба *"нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 4.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчихгүй байх

### Илрүүлэлт:

Арбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг тайлант онд "Овоо нам" ХХК, "Сүлд бумбат" ХХК-тай тус тус хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай гэрээнд заасан хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс илүү, гэрээнд заасан 13 нэр төрлийн бүтээгдэхүүнийг огт нийлүүлээгүй зэрэг нийт 6,897.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11-д "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх"-т заасныг зөрчсөн ба *"нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **2. Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой**

### 2.1 Илрүүлэлт

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах

журмыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-тай нийцэхгүй байна.

**2.2 Өгссөн зөвлөмж:**

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агуй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жолоочийн тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан байна.	1	3,730.2					1	3,730.2
Худалдан авах гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнг баримтлаагүй 6,897.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.	1	6,897.6					1	6,897.6
Цалингийн зардлаас 3,283.2 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлэн ажил олгогчийн НДШ төлсөн.	1	3,283.2					1	3,283.2
Төсвийн захирагч нь 15 багш ажилтанд нийт 15,442.6 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа нэмэгдэл хөлс тооцож олгох батлагдсан маягтыг хөтлөөгүй	1	0					1	0
Үнэлгээний баг томилохгүйгээр төсөв захирагчийн 9 удаагийн тушаалаар 28 багш, ажилтны ур чадварын нэмэгдэлд нийт 14,790.3 мянган төгрөгийг олгосон.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>13,911.0</b>					<b>5</b>	<b>13,911.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0